

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/79/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413

Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055

Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэнханд

Утас: 99147999

Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	14
4.2 Төлбөрийн акт	14
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГА Т.СҮХБАТААР ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 63
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Аймгийн аюулгүйн нөөцийн өвс тэжээлийн үнийг төлүүлээгүй, бэлнээр төлсөн мөнгийг зориулалт бусаар зарцуулсан, зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй, данснаас гадуур тооцоо үүсгэсэн, анхан шатны баримт хангалтгүй, тооллого хийж тооцоо бодоогүй, НББ-д тусгаагүй орхигдуулсан, өглөг авлагыг барагдуулаагүй, татварын хэлтсийн тодорхойлолтоор өглөг авлагатай зэрэг нийт 29.5 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аймгийн Засаг даргын захирамж, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

07020314

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>92,407,693.20</u>	<u>109,878,829.05</u>
33	АВЛАГА	12,546,700.00	12,546,700.00
335	Бусад авлага	12,546,700.00	12,546,700.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	12,546,700.00	12,546,700.00
34	УРЬДЧИЛГАА	-	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал		7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	79,860,993.20	90,132,129.05
354	Хангамжийн материал	79,860,993.20	90,132,129.05
35410	Бичиг хэргийн материал	2,463,070.00	3,011,070.00
35420	Аж ахуйн материал	75,226,723.20	86,619,059.05
35430	Сэлбэг хэрэгсэл	502,000.00	502,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>691,649,618.33</u>	<u>647,997,508.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	691,649,618.33	647,997,508.76
392	Биет хөрөнгө	510,829,618.33	468,537,508.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	437,505,311.00	437,505,311.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(55,281,821.11)	(65,637,547.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	253,615,647.00	253,615,647.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(175,121,922.32)	(194,710,383.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	81,838,197.19	81,838,197.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	(50,459,762.44)	(59,662,547.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,031,808.40	19,031,808.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,255,756.67)	(16,838,624.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,533,347.77	25,533,347.77
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,575,430.49)	(12,137,700.13)
393	Биет бус хөрөнгө	180,820,000.00	179,460,000.04
39301	Программ хангамж	7,000,000.00	7,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,180,000.00)	(3,539,999.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	176,000,000.00	176,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>784,057,311.53</u>	<u>757,876,337.81</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,033,373,907.53</u>	<u>793,475,837.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,033,373,907.53	793,475,837.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	793,641,635.93	793,641,635.93
51102	- хувийн	793,641,635.93	793,641,635.93
512	Хуримтлагдсан үр дүн	51,734,019.70	(188,164,050.02)
51210	Өмнөх үеийн үр дүн	(208,083,019.62)	51,734,019.70
51220	Тайлант үеийн үр дүн	259,817,039.32	(239,898,069.72)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	187,998,251.90	187,998,251.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,034,056,571.53</u>	<u>793,475,837.81</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,377,595,266.48	610,273,841.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	561,730,015.15	160,110,335.85
120	Нийтлэг татварын бус орлого	561,730,015.15	160,110,335.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	561,730,015.15	160,110,335.85
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	561,730,015.15	160,110,335.85
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	815,865,251.33	450,163,506.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	543,978,000.00	381,852,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	543,978,000.00	381,852,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	271,887,251.33	68,310,806.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,632,270.00	34,835,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	249,999,500.00	33,475,506.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,117,778,227.16	730,702,151.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,117,778,227.16	728,464,823.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,094,195,242.83	847,934,583.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,761,564.00	221,236,250.04
210101	Үндсэн цалин	144,551,421.00	157,998,650.43
210102	Нэмэгдэл	44,982,143.00	56,197,599.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,228,000.00	7,040,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,065,500.00	28,416,800.00
210201	Тэтгэврийн даатгал	18,342,500.00	20,234,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,930,700.00	2,045,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,544,600.00	1,636,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	353,900.00	409,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,893,800.00	4,091,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,946,388.00	13,654,100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,160,657.00	1,234,247.00
210302	Түлш, халаалт	13,352,991.00	11,508,393.00
210303	Цэвэр, бохир ус	432,740.00	911,460.00
2104	Хангамж, бараа материалын зардал	521,996,920.15	193,310,020.00
210401	Бичиг хэрэг	3,216,600.00	2,291,100.00
210402	Тээвэр, шатахуун	9,179,100.00	26,518,589.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,234,000.00	2,576,931.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	507,367,220.15	161,923,400.00

	ахуйн эд зүйлс		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
		5,437,500.00	6,104,000.00
210604	Урсгал засвар	5,437,500.00	6,104,000.00
2107	Томилолт, зочны зардал		
		24,058,700.00	21,763,400.00
210702	Дотоод албан томилолт	24,058,700.00	21,763,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
		252,661,419.00	102,531,291.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	251,589,609.00	98,172,291.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	114,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	246,810.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,000.00	230,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	69,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00
210807	Газрын төлбөр	96,000.00	96,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
		49,267,251.68	141,448,962.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	718,300.00	97,796,853.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,113,951.68	43,652,109.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
		23,582,984.33	2,237,327.96
2132	Бусад урсгал шилжүүлэг		
		21,640,600.00	2,183,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,654,500.00	2,183,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
		1,942,384.33	54,327.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,942,384.33	54,327.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	259,817,039.32	(120,428,309.72)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		(119,469,760.00)
	Үнэ төлбөргүй гарсан зардал		119,469,760.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	259,817,039.32	(239,898,069.72)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	793,641,635.93	187,998,251.90	-208,083,019.62	773,556,868.21
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	793,641,635.93	187,998,251.90	-208,083,019.62	773,556,868.21

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	259,817,039.32	259,817,039.32
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	793,641,635.93	187,998,251.90	51,734,019.70	1,033,373,907.53
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	793,641,635.93	187,998,251.90	51,734,019.70	1,033,373,907.53
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-239,898,069.72	-239,898,069.72
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	793,641,635.93	187,998,251.90	-188,164,050.02	793,475,837.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	815,865,251.33	450,163,506.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	815,865,251.33	450,163,506.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	543,978,000.00	381,852,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	543,978,000.00	381,852,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	271,887,251.33	68,310,806.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,322,000.00	34,835,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	33,475,506.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	814,765,251.33	450,163,506.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	814,765,251.33	450,163,506.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	791,182,267.00	447,926,178.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,078,900.00	218,968,699.04
210101	Үндсэн цалин	143,868,757.00	155,731,099.12
210102	Нэмэгдэл	44,982,143.00	56,197,599.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,228,000.00	7,040,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,065,500.00	28,416,800.00

Говь-Алтай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	18,342,500.00	20,234,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,930,700.00	2,045,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,544,600.00	1,636,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	386,100.00	409,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,861,600.00	4,091,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,946,388.00	13,654,100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,160,657.00	1,234,247.00
210302	Түлш, халаалт	13,352,991.00	11,508,393.00
210303	Цэвэр, бохир ус	432,740.00	911,460.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,260,800.00	9,980,736.00
210401	Бичиг хэрэг	3,120,600.00	2,839,100.00
210402	Тээвэр, шатахуун	10,294,100.00	4,471,305.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,234,000.00	2,576,931.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,612,100.00	93,400.00
2105	Нормативт зардал	312,000.00	750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	312,000.00	750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,646,000.00	6,277,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	216,000.00	173,000.00
210604	Урсгал засвар	4,430,000.00	6,104,000.00
2107	Томилолт, зочны зардал	33,058,700.00	21,763,400.00
210702	Дотоод албан томилолт	33,058,700.00	21,763,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	493,660,679.00	143,919,590.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	492,588,869.00	132,360,590.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	114,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	246,810.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,000.00	230,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	69,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	96,000.00	96,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,153,300.00	4,195,853.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	718,300.00	4,195,853.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,582,984.33	2,237,327.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,640,600.00	2,183,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,654,500.00	2,183,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,942,384.33	54,327.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,942,144.00	43,951.96
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	240.33	10,376.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	355,635,700.00	381,808,748.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355,635,700.00	381,808,748.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	353,452,700.00	379,625,748.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,968,700.00	218,968,699.04
210101	Үндсэн цалин	155,731,100.00	155,731,099.12
210102	Нэмэгдэл	56,197,600.00	56,197,599.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,040,000.00	7,040,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,416,800.00	28,416,800.00
210201	Тэтгэврийн даатгал	20,234,000.00	20,234,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,045,700.00	2,045,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,636,500.00	1,636,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	409,200.00	409,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,091,400.00	4,091,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,654,100.00	13,654,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,440,500.00	1,234,247.00
210302	Түлш, халаалт	11,205,800.00	11,508,393.00
210303	Цэвэр, бохир ус	1,007,800.00	911,460.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,982,000.00	9,980,736.00
210401	Бичиг хэрэг	2,839,200.00	2,839,100.00
210402	Тээвэр, шатахуун	4,472,200.00	4,471,305.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,577,200.00	2,576,931.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	93,400.00	93,400.00
2105	Нормативт зардал	750,200.00	750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	750,200.00	750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,277,000.00	6,277,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	173,000.00	173,000.00
210604	Урсгал засвар	6,104,000.00	6,104,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,363,400.00	21,763,400.00
210702	Дотоод албан томилолт	4,363,400.00	21,763,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,840,500.00	75,619,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,250,500.00	64,060,160.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	114,000.00	114,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,000.00	230,000.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	69,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	96,000.00	96,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,200,000.00	4,195,853.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,200,000.00	4,195,853.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,183,000.00	2,183,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,183,000.00	2,183,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,183,000.00	2,183,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	373,035,700.00	381,808,748.04
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	373,035,700.00	381,808,748.04
122005	Орон нутгийн төсвөөс	373,035,700.00	381,808,748.04

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	68,300,430.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,300,430.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,300,430.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,300,430.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,300,430.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,376.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	10,376.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	68,310,806.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	68,310,806.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,835,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,475,506.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн тогтвортой өсөлтийг хангах бодлого боловсруулах хэрэгжүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд Засгийн газрын 2021 оны 43 тогтоолоор өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 1,117.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 22.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 17.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 850.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 17.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 13.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23 хувиар буюу 240.6 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны эхний үлдэгдэл Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын авлага 12.5 сая төгрөг тайлант онд барагдуулаагүй байна.

Урьдчилгаа дансанд эцсийн үлдэгдэл 7.2 сая төгрөг байна. Энэ нь Дата ланд ХХК-руу 2022 оны программын төлбөрийг шилжүүлж, урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 90.1 сая төгрөг болж 10.24 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 46.7 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 160.1 сая төгрөгийн бараа материал авч, үйл ажиллагаандаа 410.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, оны эцэст 125.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,000.5 сая төгрөг оны эцэст хэвээр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 793.5 сая төгрөг болж 239.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 56 хувиар буюу 767.3 сая төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилт, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгө буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -188.1 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 388.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 6.9 сая төгрөгөөр бууруулж, 381.8 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 381.85 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 381.85 сая төгрөгийн санхүүжилт авч, 0.043 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 381.80 сая төгрөг буюу 100 хувьтай ба бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 0.043 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн дээд шатны төсөв захирагчаас 33.5 сая төгрөг, нөөц хөрөнгөнөөс 34.8 сая төгрөг нийт 68.31 сая төгрөгийн орлого орж, 68.3 сая төгрөгийг зарцуулж, 0.01 сая төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна. Өвөлжилт хүндрэлтэй холбоотой 29.6 сая төгрөгийг, мэргэжилтнүүдийн сургалтын зардалд 3.8 сая төгрөгийг, ямааны үйлдвэр омгийн санхүүжилтэд 33.8 сая төгрөгийг, цар тахалтай холбоотой зардалд 0.9 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хууль, Аймгийн Засаг даргын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг борлуулах 2016-2020 онуудын захирамжийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 299.3 сая төгрөгийн 55 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 158.8 сая төгрөгийн 11 мэдээллийг ил тод бүрэн байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 13.3 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.3 Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт

Аймгийн Засаг даргын 2016-2021 онд гарсан "Аймгийн аюулгүй нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийг хямдралтай үнээр борлуулах тухай" захирамжуудын хэрэгжилтийг үзэхэд дараах зөрчилтэй асуудлууд байна. Үүнд:

- Аймгийн аюулгүйн нөөцийн өвс тэжээлийн тооллого тооцооллыг бодоогүй, НББ-д тусгаагүй орхигдуулсан байна.

- Аймгийн өвс тэжээлийн нөөцийн орлогоос 5.0 төгрөгийг бэлнээр хувь хүнд өгсөн байна.
- Аймгийн өвс тэжээлийн нөөцийн зарцуулалтыг үзэхэд 2016 онд 44 боодол өвс буюу 0.2 сая төгрөг, 2018 онд 241 боодол өвс буюу 1.3 сая төгрөг, 2019 онд 5,498 боодол өвс буюу 25.0 сая төгрөгийн, 2020 онд 2,925.0 боодол буюу 14.6 сая төгрөгийн нийт 41.0 сая төгрөгийг аймгийн Гамшгийн санд төвлөрүүлээгүй байна
- Аймгийн өвс тэжээлийн нөөцийн орлогоос сүтэйн тахилгад 3.0 төгрөгийг, тээврийн хөлсөнд 2.0 сая төгрөгийг, ОБГ-ын албан хаагчид 115 боодол буюу 1.0 сая төгрөгийн өвс, бэлнээр 1.0 сая төгрөг, нийт 7.0 сая төгрөгийг зарцуулсан гэх боловч анхан шатны нотлох баримтгүй байна
- Аймгийн өвс тэжээлээс 2019 онд 305 боодол буюу 1.4 сая төгрөг, 2020 онд 1,012 боодол буюу 6.5 сая төгрөг, нийт 7.9 сая төгрөгийн хорогдол тооцсон байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны А/08 дугаар, захирамж, 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/171 дугаар захирамж, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/70, А/85 дугаар захирамж "Аймгийн аюулгүй нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийг хямдралтай үнээр борлуулах тухай" захирамжийн заалттай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.3 сая төгрөгийг залруулж, 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 34.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжүүлж ажилласан байна. Өмнөх шийдвэрийн үлдэгдэлгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар бараа материалын тайлангийн зарцуулалт, төсвийн хэмнэлтийн горим, авлагын барагдуулалт, аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийн эргэн төлөлтийг давтан тооцож шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 376.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 279.5 сая төгрөгийн алдааг залруулж, 53.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 43.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Тайлант оны үр дүнгийн тайланд 160.0 сая төгрөгийг зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

Бараа материалын тайланд хямдруулан худалдсан өвс тэжээлийн үнийн зөрүү 119.5 сая төгрөгийг худалдсан, зарцуулснаар тайлагнасан.

4.2 Төлбөрийн акт

Аймгийн өвс тэжээлийн нөөцийн орлогоос 5.0 сая төгрөгийг бэлнээр хувь хүнд өгсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/171 дугаар захирамжийн 4-т "өвс, тэжээлийн үнийг 04 дүгээр сард багтаан

гамшгийн сангийн дансанд төвлөрүүлэхийг Хүнс, Хөдөө аж ахуйн газарт даалгасугай” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул төлбөрийн акт тогтоолоо.

Аймгийн өвс тэжээлийн нөөцийн зарцуулалтыг үзэхэд 2016 онд 44 боодол өвс буюу 0.2 сая төгрөг, 2018 онд 241 боодол өвс буюу 1.3 сая төгрөг, 2019 онд 5,498 боодол өвс буюу 25.0 сая төгрөгийн, 2020 онд 2,925.0 боодол буюу 14.6 сая төгрөгийн нийт 41.0 сая төгрөгийг аймгийн Гамшгийн санд төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 2018 оны 01 дүгээр сарын 10-ны А/08 3-т “аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг сумын Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн борлуулж, үнийг гамшгийн сангийн дансанд төвлөрүүлж ажиллахыг ХХААГ-т даалгасугай.”, 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/171 дугаар захирамжийн 4-т “өвс, тэжээлийн үнийг 04 дүгээр сард багтаан гамшгийн сангийн дансанд төвлөрүүлэхийг Хүнс, Хөдөө аж ахуйн газарт даалгасугай”, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/70 дугаар захирамжийн 4-т “хуваарилагдсан өвс, тэжээлийг 2 дугаар сард багтаан төвлөрүүлж ажиллахыг аймгийн сумдын Засаг дарга нарт даалгасугай”, 2021 оны 02 дугаар сарын 26-ны А/85 дугаар захирамжтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул төлбөрийн акт тогтоолоо.

Аймгийн өвс тэжээлийн нөөцийн орлогоос сутайн тахилгад 3.0 төгрөгийг, тээврийн хөлсөнд 2.0 сая төгрөгийг, ОБГ-ын албан хаагчид 115 боодол буюу 1.0 сая төгрөгийн өвс, бэлнээр 1.0 сая төгрөг, нийт 7.0 сая төгрөгийг зарцуулсан гэх боловч анхан шатны нотлох баримтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 6.4.1-т “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/171 дугаар захирамжийн 5-т “өвс, тэжээлийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай.”, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/70 дугаар захирамжийн 5-т “өвс, тэжээлийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Аймгийн өвс тэжээлийн нөөцөөс 2019 онд 305 боодол буюу 1.3 сая төгрөг, 2020 онд 1,012 боодол буюу 6.5 сая төгрөг, нийт 7.9 сая төгрөгийн хорогдол тооцсон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 6.4.1-т “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/171 дугаар захирамжийн 5-т “өвс, тэжээлийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай.”, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/70 дугаар захирамжийн 5-т “өвс, тэжээлийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар,

аймгийн Мэргэжлийн хяналтын газар, сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Аймгийн аюулгүйн нөөцийн өвс тэжээлийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй, данснаас гадуур тооцоо үүсгэсэн, анхан шатны баримт хангалтгүй, тооллого хийж тооцоо бодоогүй, НББ-д тусгаагүй орхигдуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 6.4.1-т "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/171 дугаар захирамжийн 5-т "өвс, тэжээлийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай.", 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/70 дугаар захирамжийн 5-т "өвс, тэжээлийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн өглөг, татварын хэлтсийн тайлангаас 2.9 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн төлөвлөлтийн программ худалдан авч, 2022 оны 7.2 сая төгрөгийг төлбөрийг урьдчилж шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Засгийн газрын 2021 оны "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд 13.0 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн нь Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй,

нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговор 12.5 сая төгрөгийн Шүүхийн шийдвэрийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 299.3 сая төгрөгийн 52 мэдээллээс, 158.8 сая төгрөгийн 11 гүйлгээг мэдээлээгүй

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХХААГ	11	376.2	2	279.4	3	53.0	5	43.6	1	
	Дүн	11	376.2	2	279.4	3	53.0	5	43.6	1	

ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

1. Ерөнхий мэдээлэл

Код:	
Баримт бичгийн төрөл	Санхүүгийн тайлангийн аудлит
Аудитын нэр	Хүнс хөдөө аж ахуйн газар
Хугацаа заасан эсэх	Тийм <input type="checkbox"/> Үгүй
Ажил гүйцэтгэсэн:	Ахлах аудитор Аудитын менежер

Д.Цэрэнханд
Д.Эрдэнэчимэг

2. Гүйцэтгэсэн ажлын чанарын хяналтын эргэцийн хүснэгт

Огноо	Хүлээн авсан	Буцааж өгсөн	Чанарын хяналт хийсэн хүний шийдвэр, үнэлгээ			Чанарын хяналт хийсэн хүний санал, зөвлөмжийн товч утга	Гарын үсэг	Санал зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн хяналт	Тайлбар
			Хангалттай	Засвар, зөвлөмжийг оруулж дараагийн шатанд шилжүүлэх	Засвар хийгээд дахин үзүүлэх				
2022.02.22	2022.02.22	+				Цалингийн нөхөн төлбөр нь статистик мэдээнд байгаа юу. Шийдвэр өгөгдсөн үү.	Ж.Бүжинханд	Шийдвэрт оруулсан	
2022.02.22	2022.02.22	+				Өвс тэжээлтэй холбоотойгоор аймгийн ЗДТГ-тай тооцоо нийлүүлэх / зөрчлийг үнэлж холбогдох газарт шийдвэр өгөх	Ж.Бүжинханд	Аудитын хугацаа болсон, өмнөх ажиллагсад нь солигдсон тооллого, тооцоо бодоогүй, баримтгүй тул хяналт хийж, ЗДТГ-тай тооцоо нийлж, хяналт хий гэсэн шийдвэр өгсөн.	
2022.02.22	2022.02.22	+				Зөрчлийн дүн материаллаг түвшингээс их, өвс тэжээлийн үлдэгдлийг бүртгэлд тусгаагүй зөрчлийн улмаас баталгаажуулж байгаа тоо хэмжээ үнэн эсэхэд дүгнэлт өгөхөд хүндрэлтэй зэрэг эрсдэлүүд байхад Зөрчилгүй дүгнэлт өгч болох уу. Дүгнэлтийг засах	Ж.Бүжинханд	Нийцлийн зөрчил гэж үзсэн бөгөөд 2021 оны тус байгууллагын санхүүгийн тайланд нөлөөлөх нөлөөлөл бага гэж үзсэн тул Зөрчилгүй оруулсан	
2022.02.22	2022.02.22	+				Дараагийн шатанд хянуулах	Ж.Бүжинханд	Хянуулахаар өгсөн	
2022.02.22	2022.02.22	+				и баримттай холбоотой зөрчил заруулсан, шивэгдээгүй гээд 2 өөр байна шүү		Харж заслаа	
2022.02.22	2022.02.22	+				Аудитаар илэрсэн материаллаг зөрчил нь гүйцэтгэлийн шатанд тогтоосон материаллаг түвшнээс дээгүүр байна дүгнэлтээ эргэж харах	Д.Эрдэнэчимэг	Нийцлийн зөрчил гэж үзсэн бөгөөд 2021 оны тус байгууллагын санхүүгийн тайланд нөлөөлөх нөлөөлөл бага гэж үзсэн тул Зөрчилгүй оруулсан	
2022.02.22	2022.02.22	+				Аудитын тайлан хураангуй тайланд авлага барагдуулах зөрчил бичигдээгүй байна. Улаанаар будсан хэсгийн тоон үзүүлэлт, утгыг эргэж харах%, мөн албан шаардлага тулгаарай	Д.Эрдэнэчимэг	Тайланд оруулсан	
2022.02.22	2022.02.23	+				70.35.0 мянган төгрөг анхан шатны нотлох баримтгүй бол акт тогтоох, журам харах	Х.Түвшинбаяр	Акт тогтоолоо	
2022.02.22	2022.02.23	+				Дүгнэлт хязгаарлах	Х.Түвшинбаяр	Материаллагыг дахин үнэлж дүгнэлтийг хязгаарлав	
2022.02.22	2022.02.23	+				Шийдвэрийг Сайханжаргалгаар хянуулах	Х.Түвшинбаяр	2021.02.23-ны өдөр өгөв	

Аудитын тайланг баталгаажуулахыг зөвшөөрсөн

Дарга, Тээгүүлэх аудитор

/ Х.Түвшинбаяр/

... оны ... сарын ...
8217144139
ДЮА0050 9018301